

**“ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ СИСТЕМИЙН
ЗАГВАР АШИГЛАН ШИНЖИЛЖ ДҮРСЛЭХ НЬ”
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2019 он

“ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ СИСТЕМИЙН ЗАГВАРЫГ АШИГЛАН ШИНЖИЛЖ ДҮРСЛЭХ НЬ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгаа гүйцэтгэсэн байгууллага: “Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ,
“ТУС Солюшн” ХХК

Судалгаа гүйцэтгэсэн хугацаа: 2018 оны 7 сарын 20 - 2019 оны 2 сарын 20

Судалгаа гүйцэтгэсэн баг:

Зөвлөх:

Д.Жаргалсайхан

“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын тэргүүн,
Уул уурхайн эдийн засагч, ШУТИС-ийн хүндэт
профессор

Судалгааны зохицуулагч:

Батсайханы Баярцэнгэл

Бизнесийн удирдлага, Бизнесийн удирдлагын
магистр

Судлаачид:

Дашжамцын Цогзолмаа

Сэтгэл судлаач, Сэтгэл судлалын ухааны доктор,
дэд профессор

Ундрахын Батзориг

Математикч, Онолын математикийн доктор

Мөнхбаярын Ванчигмаа

Олон улсын эрх зүйч, өмгөөлөгч, Хууль зүйн докторант

Дашдаваагийн Бадамдаш

Улс төр судлаач, Улс төр судлалын магистр

Ёндонжамц Энхбаяр

Философич, Философийн ухааны магистр

Нэргүйбаатарын Батзориг

Социологич, Социологийн магистр

Лувсандандарын Долгор

Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, Нийгмийн
эрүүл мэндийн магистр

Батсайханы Баярцэнгэл

Бизнесийн удирдлага, Бизнесийн удирдлагын
Магистр

Баярсайханы Хулан

Эрх зүйч

Монгол хэлний найруулга зүйн зөвлөгөө өгсөн:

Сүхбаатарын Ганцэцэг

МУБИС-ын сэтгүүл зүйн багш, Хэл шинжлэлийн
ухааны доктор, дэд профессор

Тайлан нэгтгэсэн:

Лувсандандарын Долгор

“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын судлаач

Зургийн болон хэвлэлийн эх бэлтгэсэн:

Цогдэлгэрийн Сэнгэдовдон

“ТУС Солюшн” ХХК-ийн Контент менежер

Монгол улсын Үндсэн хуулийн судалгааны өнөөгийн байдал

Монгол улсын дөрөвдүгээр Үндсэн хууль 1992 оны нэгдүгээр сарын 13-нд батлагдснаас хойш энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл хийгдсээр байгаа юм. Эдгээрээс зарим томоохон бүтээлүүдийг дурьдвал Улс төрийн боловсролын академиас 1999 онд хэвлүүлсэн “Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал”, Үндсэн хуулийн “эх баригч”, эрдэмтэн Бяраагийн Чимидийн 2002 онд хэвлүүлсэн “Үндсэн хуулийн үзэл баримтлал” П.Амаржаргалын 2015 онд хэвлүүлсэн “Үндсэн хуулийн эрх зүй, Парламентын онол үзэл баримтлалын асуудал”, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцээс эрхлэн хэвлүүлсэн “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал”, Бяраагийн Чимидийн нэрэмжит Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, оюутны эрдэм шинжилгээний бага хурлаас шалгарсан илтгэлүүдийг нэгтгэн 2016 онд хэвлүүлсэн “Үндсэн хууль ба эрх зүйт ёс”, Д.Гангабаатарын 2017 онд “Үндсэн хуулийн эрх зүй: төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал”, Б.Нармандах, Н.Мөнхзул нарын 2017 онд хэвлүүлсэн “Үндсэн хуулийн өөрчлөлтийн эргэн тойронд” ном, П.Очирбатын 2018 онд хэвлүүлсэн “Монгол улсын Үндсэн хууль: хэрэгжилт, хяналт, судалгаа” зэрэг бүтээлүүд юм.

Дээрх бүтээлүүд нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын эрх зүйд хамаарах бол нийгмийн онол арга зүйн шинжтэй Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тусгасан тодорхой судалгаа шинжилгээний ажил одоогоор алга байна.

Монгол улсын Үндсэн хуулийг нийгмийн тогтолцооны шийдлийн үүднээс судлах хэрэгцээ, шаардлага

Үндсэн хуулиар тодорхойлсон “...Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд уг зорилгыг өөр өөрсдийн үзэмжээр тайлбарлан, Үндсэн хуульд тусгасан нийгмийн нэгдмэл хэв шинжүүдийг цогцоор нь бус салангид байдлаар ойлгон хэрэглэж байгаагаас нийгэм Үндсэн хуулиар баталгаажуулсан зорилгоо хэрэгжүүлэхэд гажуудал үүсч байна. Энэ гажуудал нь нийгэм эдийн засгийн бүх түвшинд зөрчил, үл ойлголцол, асуудлыг дагуулж дээрх зорилгод итгэх итгэлийг алдагдуулж байна.

Иймд дээрх гажуудлыг үүсгэж буй суурь шалтгаануудыг олж тодорхойлон, эдгээр шалтгааны тухай олон нийтийн ойлголтыг нэгдмэл болгох хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Судалгааны зорилго: Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцоонд системийн шинжилгээ хийх замаар нийгэмд гажуудал үүсгэж буй суурь шалтгаануудыг тодорхойлж, Үндсэн хуулиар тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэх чадвартай нийгмийн тогтолцооны тухай олон нийтийн ойлголтыг нэгтгэхэд дөхөм болохуйц загварын дүрслэл боловсруулах.

Судалгааны зорилт:

1. Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцоонд системийн шинжилгээ хийж нийгмийн гажуудал үүсгэж буй суурь шалтгааныг тогтоох.

2. Үндсэн хуулиар тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэх чадвартай нийгмийн тогтолцооны тухай олон нийтийн ойлголтыг нэгтгэхэд дөхөм болохуйц загварын дүрслэл боловсруулах

Практик ач холбогдол:

1. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд үүссэн гажуудлын суурь шалтгааныг тогтоосноор түүнийг арилгах арга замуудыг тодорхойлох боломж бүрдэнэ.
2. Үндсэн хуулиар тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэх чадвартай нийгмийн тогтолцооны загварын дүрслэлийг бий болгосноор уг зорилгыг хэрэгжүүлэгч оролцогч талуудын ойлголтыг нэгтгэх үр дүнтэй хэрэгсэл бий болно.
3. Үндсэн хуулиар тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэх чадвартай нийгмийн тогтолцооны тухай нэгдмэл ойлголтыг бий болгосноор Үндсэн хуулиар тодорхойлсон нийгмийн эрхэм зорилгод итгэх олон нийтийн итгэл нэмэгдэнэ.

Судалгааны шинэлэг тал:

Үндсэн хуулийн эрх зүйн орчинд системийн загвар ашиглан шинжилгээ хийж үзэж байгаад оршино.

Энэхүү судалгаанд хэрэглэсэн үндсэн ойлголтын тайлбар

1. Систем - Нэгдмэл зорилготой, харилцан уялдаатай элементүүдийн нэгдэл.
2. Системийн хэв шинж- Зорилгоо тогтвортой, тууштай хэрэгжүүлэхэд зайлшгүй бүрдүүлэх шаардлагтай шалгуур хэв шинжүүд.
3. Хэвийн үйл ажиллагаатай систем- Гадаад орчны өөрчлөлтөөс үл хамааран нэгдмэл зорилгоо тогтвортой, тууштай хэрэгжүүлэх чадвартай систем.
4. Эрхэм зорилго - Монгол улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт тодорхойлсон нэгдмэл зорилго.
5. Нийгэм - Өөрсдийнхөө хэрэгцээг хангах нэгдсэн зорилгоор тодорхой хил хязгаарт харилцан уялдаатай үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн нэгдэл.
6. Загвар - Аливаа ойлголтыг тодорхойлдог, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэв шинжүүдийг ойлгомжтойгоор хялбаршуулсан дүрслэл.
7. Үүрэг -Тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх, эрх зүйн актаар байнгын мөрдөх хэм хэмжээ болгон тогтоосон үйлдлүүд.
8. Мониторинг - Системийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор эмх цэгцтэйгээр мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүгнэлт гаргах үйл явц.
9. Оролцогч тал - Тухайн зорилгыг хэрэгжүүлэхэд үүрэг гүйцэтгэн оролцож, үр шим хүртдэг хувь хүн, хуулийн этгээд.
10. Гажуудал - Зорилгоос хазайсан үйлдлүүдийн улмаас тухайн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн гажиг
11. Хэв шинж - Аливаа зүйлийг бусад зүйлсээс ялгаж улмаар танин мэдэхэд зайлшгүй хэрэглэгддэг, тухайн зүйлийн онцлогийг илэрхийлсэн чанар болон тэмдэглэгээнүүд.

Судалгааны арга, аргачлал

Системийн онол, системийн шинжилгээний тухай: Системийн онол, сэтгэлгээ нь XIX зуунаас хөгжиж ирсэн бөгөөд системийн ерөнхий онолыг тодорхойлсон Карл Людвиг фон Бергаланфи, системийн хандлагын менежментийг үндэслэгч Руссел Акоф, оюун санааны загварыг боловсруулсан Питер Сенге, системийн зохицол ба тэнцвэртэй байдлын үндэслэгч Уильям Росс Эшби нар гол төлөлөгчид нь юм.


Системийн онол, логик сэтгэлгээний арга зүй, сэтгэл зүйн шинжлэх ухаанд суурилсан тохиргоотой угсардаг системийн /ТУС/ шийдлийг ТУС Солюшн компани боловсруулсан. Энэхүү шийдлээр аливаа нийгэм, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг (гэр бүл, байгууллага, төр, салбар гэх мэт) доор дурдсан 5 дэд тогтолцоог бүрдүүлж, шаардлагатай тодорхой хэв шинжүүдийг бий болгох замаар хэвийн үйл ажиллагаатай буюу зорилгоо тууштай хэрэгжүүлэх чадвартай систем болгож болно гэж үздэг. Хэвийн үйл ажиллагаатай систем нь

1. Үзэл баримтлалын дэд тогтолцоо
2. Үүргийн дэд тогтолцоо
3. Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо
4. Эргэх холбооны дэд тогтолцоо
5. Хэмжүүр үзүүлэлтүүдийн дэд тогтолцоонуудаас бүрдэнэ.

“ТУС” шийдлийн учир шалтгааны үндэслэлийг системийн логикийн зураглал буюу ТУС загвараар дүрсэлж илэрхийлдэг. ТУС загвар нь тухайн системд оролцогч талуудын суурь хэрэгцээнүүдийг уялдуулан нэгдмэл зорилго бүхий, харилцан үүрэг хүлээж, үр шим хүртдэг тогтолцоог дүрслэн харуулж, оролцогч талуудын ойлголтыг нэгтгэх боломжийг бүрдүүлдэг онцлогтой юм.

Мөн ТУС Солюшн ХХК нь дээрх загвараар тодорхойлсон хэв шинжүүдэд үндэслэн аливаа системийн төлөв байдал, түүний үйл ажиллагааны гүйцэтгэл болон үр дүнг тоон утгаар хэмжих шинжилгээ, оношилгооны аргачлалыг боловсруулсан. 2016-2018 онд энэхүү аргачлалыг төрийн, төрийн бус болон бизнесийн салбарын нийт 30 гаруй байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаанд шинжилгээ, оношилгоо хийх замаар туршиж үзсэн. Эдгээр шинжилгээ, оношилгооны үр дүнд тухайн системүүдэд асуудал үүсгэж буй шалтгаан буюу системийн доголдлуудыг субъектив бус байдлаар оновчтой илрүүлж чадаж байгаа нь нотлогдсон. Ингэснээр шинжилгээ, оношилгоонд хамрагдсан байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд асуудал үүсгэж буй доголдлыг шуурхай илрүүлэн, засаж залруулах боломж бүрдэж байна.

Зураг 1. Хэвийн үйл ажиллагаатай системийн “ТУС” загвар



Түүнчлэн нийгмийн судалгаанд өргөн хэрэглэдэг ярилцлага, баримт бичигт дүн шинжилгээ хийх болон агуулгад дүн шинжилгээ хийх /контент-анализ/ зэрэг аргуудыг ашиглав.

Судалгаа хийхэд мөрдсөн зарчмууд:

1. Баримт, нотолгоонд тулгуурлан дүгнэлт гаргах
2. Тогтоосон аргачлалыг мөрдөх

Судлагдахууны хүрээ:

Энэхүү судалгаанд Монгол улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудад шууд хамаарах тусгайлсан болон бусад хуулийг хамруулав.

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

1. Монгол улсын иргэдийн нэгдмэл зорилгыг Үндсэн хуулийн оршилд "... Монголын ард түмэн бид Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх" гэж тодорхойлсон нь нийгмийн оршин тогтнох үндэслэл болж байна.
2. Үндсэн хуулийн үзэл баримтлал нь зорилгоо хэрэгжүүлэх чадвартай нийгмийн тогтолцооны суурь хэв шинжүүдийг бүрдүүлэхэд шаардлагатай шийдлүүдийн логик үндэслэлүүдийг агуулж байна.
3. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд төрийг төлөөлж оролцох үүрэгтэй Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүх, Прокурорын байгууллага, Нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох хуулиар тогтоосон үйл ажиллагааны зорилго нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгт захирагдахгүй байна.

4. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд төрийг төлөөлж оролцох үүрэгтэй байгууллагуудаас зөвхөн Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны зорилго нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгт захирагдаж байна.
5. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд болох улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоогоогүй байна.
6. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг холбогдох хуулиар тогтоогоогүй учир “**Эрхэм зорилго**”-ынхоо хэрэгжилтийг оролцогч талууд нэгдмэл байдлаар хэмжиж чадахгүй байна.
7. Үндсэн хуулиар тодорхойлсон Эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд мониторинг хийх үүрэг бүхий этгээдийг холбогдох хуулиар тогтоогоогүй учир “**Эрхэм зорилго**”-ын хэрэгжилт, түүний үр дүнд нэгдсэн мониторинг хийгдэхгүй байна.
8. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд төрийг төлөөлж оролцох үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудын хүртэх үр шим нь уг зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаарахгүй байгаа нь тухайн оролцогч талууд “**Эрхэм зорилго**”-оо хэрэгжүүлэхэд сэдэлжүүлэхгүй байна.
9. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ын хэрэгжилтийг хэмжих шалгуурыг тогтоогоогүйн улмаас “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд төрийг төлөөлж оролцох үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргээс гадуур үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байна.
10. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоогоогүй учир “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй суурь шалтгаануудыг олж тогтоох боломжгүй байна.
11. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангаа иргэдээр хэлэлцүүлэх үүргийг холбогдох хуулиар тогтоогоогүй учир “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтанд иргэн бүр оролцох боломжийг хязгаарлаж байна.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

1. Системийн онол, логик сэтгэлгээний арга зүй, сэтгэл зүйн ухаанд суурилсан системийн шинжилгээний “**ТУС загвар**”-ыг ашиглан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцооны загварыг баримтжуулан дүрслэх боломжтой байна.
2. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцооны загварыг баримтжуулан дүрсэлснээр уг загварыг нийтээр хэлэлцэх, ойлголтоо нэгтгэх суурь болж байна.

3. ТУС загварт тулгуурлан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн, хүний эрх төвтэй /ХЭТ/ нийгмийн загварыг боловсруулан, дүрслэх боломжтой байна.


Зураг 2. Үндсэн хууль болон тусгайлсан хуулиудын зохицуулалтанд суурилсан нийгмийн тогтолцооны дүрслэл



Зураг 3. Үндсэн хуулийг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцооны “ХЭТ-16” загвар



Зураг 4. Үндсэн хуулийг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцооны “ХЭТ-16” загвар



СУДАЛГААНЫ НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

1. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд төрийг төлөөлж оролцох үүрэгтэй Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүх, Прокурорын байгууллага, Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны зорилгыг Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгт захируулах.
2. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын нэгээр тодорхойлогдсон улс төрийн намын үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт нийцүүлэн холбогдох хуулиар тодорхойлох.
3. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхүүдийн хэрэгжилтийг иргэний эрх тус бүрээр хэмжих хэмжүүрийг тодорхойлох.
4. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ын хэрэгжилтийн үр дүнг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрхүүдийн хэрэгжилтийн нэгдсэн хэмжүүрээр хэмждэг болох.
5. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг боловсруулан холбогдох хуулиар тогтоох.
6. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын зорилгоо хэрэгжүүлэх үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий иргэний төлөөллийн байгууллагыг холбогдох хуулиар тогтоох.


7. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд төрийг төлөөлж оролцох үүрэгтэй байгууллага, албан тушаалтнуудын хүртэх үр шим нь “**Эрхэм зорилго**”-ын хэрэгжилтийн үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох.
8. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоох.
9. Үндсэн хуулиар тодорхойлсон “**Эрхэм зорилго**”-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангаа иргэдээр хэлэлцүүлэх үүргийг холбогдох хуулиар тогтоох.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

1. Системийн онол, логик сэтгэлгээний арга зүй, сэтгэл зүйн ухаанд суурилсан Системийн шинжилгээний “**ХЭТ /хүн эрх төвтэй/ системийн загвар**”-ыг ашиглан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нийгмийн тогтолцооны загварыг баримтжуулсан дүрслэлийг олон нийтээр хэлэлцүүлэх.

ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НИЙГМИЙН ОРОЛЦОГЧ ТУС БҮРТ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Зураг 5. Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж буй нийгмийн тогтолцооны дүрслэл



1. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Судалгааны дүгнэлт

1. Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг "Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллах, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг, улс төрийн хүчнүүдийн хооронд дэмжлэг үзүүлэх" гэж Ерөнхийлөгчийн тухай хуулиар тодорхойлсон нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасан Ерөнхийлөгчийн үүрэгт нийцэхгүй байна.
2. Ерөнхийлөгчийн тухай хуульд Ерөнхийлөгчийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуур, хүлээлгэх хариуцлагыг тогтоогоогүй байна.
3. Ерөнхийлөгчийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд мониторинг хийх үүрэг бүхий этгээдийг Үндсэн хууль болон холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
4. Ерөнхийлөгчид эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан

төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчийн хүлээх үүргийн гүйцэтгэл болон үр дүнгээс хамаарахгүй байна.

5. Ерөнхийлөгчийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг бий болгож буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг Ерөнхийлөгчийн тухай хуулиар тогтоогоогүй байна.
6. Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчийн хүлээх үүрэгтэй уялдуулан төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байхаар холбогдох хуулиар тогтоогоогүй байна.

Судалгааны санал зөвлөмж

1. Ерөнхийлөгчийг зөвхөн Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлдэг байхаар холбогдох хуулиар тогтоох
2. Ерөнхийлөгчийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл болон үр дүнг хэмжих шалгуурыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрх, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгт нийцүүлэн холбогдох хуулиар тогтоох.
3. Ерөнхийлөгчийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий олон нийтийн байгууллагыг холбогдох хуулиар тогтоох.
4. Ерөнхийлөгчид эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлагыг Ерөнхийлөгчийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох
5. Ерөнхийлөгчид эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчийн хүлээх үүргийн гүйцэтгэл болон үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох
6. Ерөнхийлөгчийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоох.
7. Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрх, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчийн хүлээх үүрэгтэй уялдуулан төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байхаар холбогдох хуулиар тогтоох.

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Судалгааны дүгнэлт

1. Улсын Их Хурлын зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгтэй нийцүүлэн хуулиар тогтоогоогүй байна.
2. Улсын Их Хурал зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг хуулиар тогтоогоогүй байна.

3. Улсын Их Хурал зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд мониторинг хийх үүрэг бүхий этгээдийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
4. Улсын Их Хурлын гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Улсын Их Хурлын зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл түүний үр дүнгээс хамаарахгүй байна.
5. Улсын Их Хурлын гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын гүйцэтгэх үүргийн гүйцэтгэл болон үр дүнгээс хамаарахгүй байна.
6. Улсын Их Хурал зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
7. Улсын Их Хурлын үйл ажиллагааг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын гүйцэтгэх үүрэгтэй уялдуулан төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байх үүргийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.

Судалгааны санал зөвлөмж

1. Улсын Их Хурал аливаа хуулийг батлахдаа уг хуулийн зорилгыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийцүүлдэг байх үүргийг холбогдох хуулиар тогтоох
2. Улсын Их Хурал зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл болон үр дүнг хэмжих шалгуурыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгт нийцүүлэн холбогдох хуулиар тогтоох.
3. Улсын Их Хурлын зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий олон нийтийн байгууллагыг холбогдох хуулиар тогтоох.
4. Улсын Их Хурлын гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын гүйцэтгэх үүргийн гүйцэтгэл болон үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох
5. Улсын Их Хурал зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоох
6. Улсын Их Хурал үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын гүйцэтгэх үүрэгтэй уялдуулан төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байх үүргийг холбогдох хуулиар тогтоох.

3. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Судалгааны дүгнэлт

1. Засгийн газрын үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг "Монгол Улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж Засгийн газрын тухай хуулиар тодорхойлсон нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 -т заасан төрийн үндсэн чиг үүрэгт нийцэхгүй байна.
2. Засгийн газрын зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
3. Засгийн газар зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд хөндлөнгийн мониторинг хийх үүрэг бүхий этгээдийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
4. Засгийн газрын бүтцийн ажилтнуудад эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Засгийн газрын зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаарахгүй байна.
5. Засгийн газрын бүтцийн ажилтнуудад эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын гүйцэтгэх үүргийн гүйцэтгэл болон үр дүнгээс хамаарахгүй байна.
6. Засгийн газар зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргээ гүйцэтгэхэд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
7. Засгийн газар үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын гүйцэтгэх үүрэгт нийлцүүлэн төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байх үүргийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.

Судалгааны санал зөвлөмж

1. Засгийн газар нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан хүний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан хуулиудын хэрэгжилтийг хангах үүрэгтэй байхаар холбогдох хуулиар тогтоох
2. Засгийн газар зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрх, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүрэгт нийцүүлэн холбогдох хуулиар тогтоох.
3. Засгийн газар зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий этгээдийг холбогдох хуулиар тогтоох
4. Засгийн газрын бүтцийн ажилтнуудад эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлагыг Засгийн газрын зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох
5. Засгийн газрын бүтцийн ажилтнуудад эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлагыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын гүйцэтгэх үүргийн гүйцэтгэл болон үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох

6. Засгийн газар зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэхэд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоох
7. Засгийн газар үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Засгийн газар гүйцэтгэх үүрэгт нийцүүлэн төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байх үүргийг холбогдох хуулиар тогтоох.

4. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

Судалгааны дүгнэлт

1. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг "Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж Үндсэн хуулиар тодорхойлсон нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрийн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэж байна.
2. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг "БҮРЭН ЭРХ" гэдэг ойлголтоор тодорхойлсноос Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны зорилго буюу үүрэг нь үзэмжийн чанартай буюу зайлшгүй хэрэгжих хэв шинжийг бүрдүүлээгүй байна.
3. Үндсэн хуулийн цэц зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
4. Үндсэн хуулийн цэц зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий этгээдийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
5. Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлага нь Үндсэн хуулийн цэцийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаарахгүй байна.
6. Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээх хариуцлага нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гүйцэтгэх үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаарахгүй байна.
7. Үндсэн хуулийн цэцийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүнийн үр дүнд үүссэн болон үүсэж болзошгүй хүндрэлийг үүсгэж буй шалтгааныг олж тогтооход зайлшгүй шаардлагатай шалгуур, мэдээлэл, үүргүүдийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.
8. Үндсэн хуулийн цэцийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэлийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гүйцэтгэх үүрэгт нийцүүлэн төлөвлөж, иргэдээр хэлэлцүүлдэг байх үүргийг холбогдох хуулиар тогтоогоогүй байна.

Судалгааны зөвлөмж

1. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны зорилго буюу нийгэмд хүлээх үүргийг үзэмжийн

чанартай бус, зайлшгүй хэрэгжих хэв шинжээр тодорхойлж холбогдох хуульд тусгах

2. Үндсэн хуулийн цэц зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнг хэмжих шалгуурыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийг хангах, 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн үүргийг хэрэгжүүлэхэд нийцүүлэн холбогдох хуулиар тогтоох.
3. Үндсэн хуулийн цэц зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий иргэдийн төлөөллийн байгууллагыг холбогдох хуулиар тогтоох.
4. Үндсэн хуулийн цэц зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнд хараат бус мониторинг хийх үүрэг бүхий иргэдийн төлөөллийн байгууллагыг холбогдох хуулиар тогтоох.
5. Үндсэн хуулийн цэцгийн гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлагыг Үндсэн хуулийн цэцийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох
6. Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд эдлүүлэх нийгмийн баталгаа, хүлээлгэх хариуцлагыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхийн хэрэгжилт болон 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гүйцэтгэх үүргийн гүйцэтгэл, түүний үр дүнгээс хамаардаг байхаар холбогдох хуулиар тогтоох
